

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН ДАХЬ "...ЗУНЫ ТЭРГҮҮН САРЫН АРВАН ЗУРГААНЫ УЛААН ТЭРГЭЛ ӨДӨР..."

¹И. Саруул

²Э. Жигмэддорж

¹Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Угсаатан судлалын тэнхим

²Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн 2-р курсийн овутан

Түлхүүр үг: Зуны тэргүүн сарын арван зургааны улаан эргэл өдөр, сүсэг бишрэл, нүүдэллэн аж төрөх, монголын нууц товчоо

Монголын нууц товчоон дахь "...Зуны тэргүүн сарын арван зургааны улаан эргэл өдөр ..."

"Монголын нууц товчоон"-нд Монголчуудын нүүдлийн соёл иргэншлийн холбогдолтой асуудлууд нилээд тусгагдсан байдгийн дотороос "Зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр" гэж урван удаа тэмдэглэгдсэн явдал бидний анхаарлыг татсан юм. Тухайлбал:

1) 81-р зүйлд дурьдсанаар "Temüžin-I Taryutai-kiriltuy abcu odcu ulis irgen-dür "(i)-jen žasagdažu ail-dur nigen gonojulun ditügülün jabuqi-tur žun-u terigun sara-jin harban žiryojan-a hulayan terhel üdür taicijud onan-(u)u ergi degere gurimlaidužu naran šuhgegesü targaba. Temüžin-I tere gurim-dur gelbüre kögön abëiražu bülege. Qurim-un naran-I targajulun tere gelbüre kögön-ece buyaju tatažu abcu heki in-ü niqete deledüged qüjiž onan-(n)-u dün dотора kedtegesü üzegdezi kegžü usun-u garki-dur gederqü kebtežü buycu-ban usun huruju ursyan niyur ile kebtebe" (16.т.99.).

2) 118-р зүйлд "Temüžin, žamuqa gojar amaraldurun nigen hon nököge hon-u žarim amaraldužu tere aysan nutuy-ača nigen üdür negüje kegeldüžü neğürün žun-(n)u terigün sara-jün harban žiryojan-a hulayan tergel üdür negübe" (16).

3) 193-р зүйлд "qulayana žil žun-u teriqun safa-jin harban žiryojan üdür hulayan tergel-e tur tačuyad morilarun" (16.т.474.) гэжээ.

Дээрх гурван зүйлээс үзвэл энэхүү өдөр нь монголчуудын нүүдэллэн аж төрөх ёсон, хурим найр хийх, дайн тулаанд мордох зэргийн үйл хэрэгтэй холбоотой дурьдагдаж байгаа юм. Иймд Монголчуудын танин мэдэхүй, сүсэг бишрэлд чухам ямар учраас энэ өдрийг онцлон үзэх болсон, түүний шалтгааныг тодруулах оролдлого хийж байна.

Уг өдрийн талаар зарим эрдэмтэн судлаачид өөр өөрсдийн санал дүгнэлтийг хийсэн байх бөгөөд ихэвчлэн мал аж ахуй, түүн дотороо нүүдэллэн аж төрөх ёстой холбон тайлбарласан байна. Эдгээрээс нягталбал:

Эрдэмтэн Д. Гонгор Халх товчоон бүтээлдээ "Зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр гэсэн нь өвөлжөө хаваржаанаас зусланд нүүдэллэх тогтмол өдөр байсан (4.т.312.), өөрөөр хэлбэл, тухайн үеийн Монгол аймгууд нүүдэллэх нэгэн тогтмол өдөртэй байжээ" гэсэн буй. Тэрбээр уг өдрийг гагцхүү Тэмүжин, Жамуха нарын шинэ газар буух, нутаг сэлгэх тухай хэсэгт тулгуурлан нүүдэллэх ёстой холбожээ. Нэрт монголч эрдэмтэн В.Я. Владимирцов мөн энэ үйл явдалтай тайлбарлаж санал нийлжээ (2.т.56.).

А. Нямаа "Эзэнт гүрний үед...ав, хомрого, нүүдэл хийх, аян дайнд мордход цаг улирлын тохиромжтой байдлыг сонгон авдаг ёс байжээ" гээд

"...Зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр бол хурим найр, нүүдэл хийх, туг тахиx, аян дайнд мордох өлзий хишиг өдөр" (9.т.55-56.) гэжээ.

Эрдэмтдийн дэвшүүлж буй саналыг хураангуйлбал "Зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр" гэсэн нь тухайн үеийн нүүдэлчин Монголчуудын нүүдэллэн амьдрахуй ёсны онцлогийг тусган харуулсан бөгөөд тэр нь нарийн дэг журамтай, өөрөөр хэлбэл, өвөлжөө хаваржаанаас зусланд буух тохиромжтой сайн өдөр байсан, ер нь Монголчууд алиев нэг нүүдлийг хийхдээ цаг улирлын тохиромжтой байдлыг сонгодог байжээ гэж үзэхэд хүргэж байгаа юм.

Гэтэл Монголын нууц товчоонд уг өдрийг зөвхөн өвөлжөө хаваржаанаас зусланд буух, хурим найр хийх, аян дайнд мордох зэрэгт тохиромжтой сайн өдөр байснаар хязгаарлагдах бус, энэ нь монголчуудын танин мэдэхүй, ертөнцийг үзэх үзэл, байгал цаг улиралтай холбоотой нарийн мэдлэг, тэрч байтугай аливаа далдын зүйлд итгэх, бишрэн шүтэх явдалтай ямар нэгэн байдлаар холбогдож байгаа төдийгүй тухайн үеийн Монгол нутаг дахь аймаг ханлигуудын соёл, ахуй, заншил хоорондоо адилаатар байсныг илэрхийлэх нэгэн хүчин зүйл болж байна.

Учир юун гэвэл тэр цагийн монголчууд энэ өдөр алиев нэг хэрэг явдлыг эхлүүлдэг, цаашлаад хөдөлмөр ахуйн шинэ сэргэлтийн илэрхийлэл болж байсан нь түүхийн тулгар сурвалжууд болон европ жуулчдын тэмдэглэл дэх зарим мэдээ сэлтээс мэдэгдэж байна. Тухайлбал: Юан тулсын үед Хубилай хааны дэргэд 17 жил амьдарсан Марко Поло өөрийн аян замын тэмдэглэлдээ тэр цагийн Монголчуудад тахилга тайлга хийх, алиев үйл хэргийг эрхлэх тухайлсан өдрүүд байсныг дурьдаад "Том тахилга тайлга хийх үедээ их магтаал дуудлага эгшиглүүлэн, урьд огт үзэгддэггүй гэрэл гэгээ бадраана" (7.т.82.) гэсэн байдаг бол **Плано Карпини зохиолдоо** "Тэд (Монголчууд-Э.Ж.) аливаа ажил үйлс эхлэхдээ заавал сар шиний юм уу эсвэл тэргэл сартай үед (өдөр) эхэлнэ" (11.т.19.) гэжээ. Эндээс үзэхэд XIII зууны үеийн Монголчуудын цаг тоо, зурхайн ухааны мэдлэг нилээд өндөр түвшинд хөгжсөнийг харуулах бөгөөд түүнийгээ өдөр тутмын амьдрал ахуйдаа бүтээлчээр хэрэглэж байжээ.

Монголын нууц товчоонд тэмдэглэснээр Чингис хаан уг өдөр **Найман аймагтай байлдахаар мордсон** нь цаад утгаараа ажил үйлсээ амжилттай байхыг бэлгэдсэний зэрэгцээ энэ өдөр аливаа зүйл эхлүүлэхэд өлзийтэй сайн хэмээн итгэж байсны илэрхийлэл бизээ. **Өөрөөр хэлбэл, Тэмүжин энэхүү дайнд ялсан нь түүий цаашдын үйл ажиллагаанд ихээхэн чухал үүрэг гүйцэтгээд зогссонгүй "Чингис" хэмээх нэрийг Монгол овог аймгууд болоод дэлхийн нийтэд цуурайтах эхлэл болсон ажгуу.**

Дурьдан буй өдөртэй холбоотой өөр нэгэн сонирхолтой зүйл бол Лу "Алтан товч"-ид: "Чингис хаан хар морин жилийн зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр төрсөн" (1.т.18.) гэж тэмдэглэсэн байна. Энд Монголчуудын эртнээс нааш эрхэмлэн ирсэн аливаа хүнийг хүндэтгэн дээдлэх заншлын улбаа илэрч байгаа юм. Өөрөөр хэлбэл, манай өвөг дээдэс эртнээс ухаан цэцэн, эрдэм төгс, суу зальтай, олныг дагуулж чадах эрэлхэг зоригт, баатар эрс эгэл жирийн бус өлзийт сайн өдөр тэнгэрийн ерөөлөөр төрдөг хэмээн итгэж, сүжиглэж явжээ.

Монголын түүхийн бусад сурвалж тухайлбал: Саган сэцэний "Эрдэний товч" (14.т.82.), Гүн Гомбожавын "Гангын урсгал" (5.т.5.) зэрэгт Тэмүжинг энэ өдөр төрсөн гэж бичсэн зүйлгүй. Харин судлаачдын ихэнх нь Чингис хааныг эл өдөр төрсөн хэмээн өөрсдийн зохиол бүтээлдээ тэмдэглэжээ. Тухайлбал: Академич Н. Ишжамц Тэмүжинг билгийн 3-р жарны усан морин жилийн зуны тэргүүн сарын арван зургаан, аргын 1162 оны 5-р сарын 31-нд (6.т.39.), Ш. Нацагдорж 3-р жарны усан морин

жилийнзуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр буюу 1162 оны 4-р сарын 16-нд (10.т.24.), Ч. Далай 3-р жарны усан морин жилийн зуны тэргүүн сарын арван зургаан буюу 1162 оны 4-р сарын 26-нд (6.т.40.), БНХАУ-ын эрдэмтэн Сайшаал “Чингис хааны товчоон” зохиолдоо 3-р жарны усан морин жилийн зуны тэргүүн сарын арван зургаанаа буюу 1162 оны 4 сарын 16-нд төрсөн (12.т.15.) хэмээн тус тус бичсэн байна. Уг эрдэмтэд Тэмүжинг нийтийн он тооллын хэдний өдөр төрсөн гэдэг дээр хоорондоо санал зөрсөн боловч түүхийн сурвалж баримтыг үндэслэн зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр төрсөн гэдэг дээр нэгдмэл саналтай байгаа юм.

“Зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр” нь Чингис хаан, түүний үйл ажиллагаатай холбоотой дурьдагдаж байгаа нь Чингис хаан энэ өдрийг эрхэмлэж байжээ гэж үзэхэд хүргэж байна. Чингис хаан эл өдрийг тохиолдуулан аливаа хэрэг явдлыг явуулдаг, тэрч байтугаа уг өдрийг хүлээж алиев үйлийг хийж бүтээдэг, тахилга үйлддэг байсан байж болох юм. Учир юун гэвэл Марко Поло, Плано Карпини нарын тэмдэглэл дэхь зүйл, Тэмүжин энэ өдөр төрсөн (Лу. Алтан товч, 18-р тал.), Монголын нууц товчоонд өгүүлсэнээр Чингис хаан Жамухтай нүүе хэмээн хэлэлцсэн (118 зүйл.), Найманыг дайлхаар мордсон (193 зүйл.), Тайчуд аймгаас зугтсан (81 зүйл.), Тайчуд аймаг их хурим найыр хийн шөнө орой тарсан (81 зүйл.) зэрэг нь өдөр цөм давахцан тохиож буй.

Чингис хаан Тайчуд аймгаас зугтан амь гарсан билгийн улиралын зуны тэргүүн сарын арван зургааны билэгтэй, өлзийтэй өдөр нь түүний энэ насны амьдралд зайлшгүй чухал ач холбогдолтой байсан хэмээн судлаачид үздэг (17.т.191.). Өөрөөр хэлбэл, энэ удаагийн хэрэг явдлаар Тэмүжин анд нөхрийн тус дэмжлэг, тэдний үүрэг нөлөөг таньж мэдсэн бөлгөө.

Ийнхүү Монголын нууц товчоон дахь “Зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр” нь зөвхөн Монголчуудын уламжлалт мал аж ахуй, нүүдэллэх ёстой холбоотой байгаад зогсохгүй илүү олон талыг хамарсан өргөн ойлголт болох нь дээрх зүйлүүдээс илэрхийн дээр:

- **Зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдрийг тохиолдуулан ямар нэгэн хэрэг явдлыг эхлүүлэх, аян дайнд мордох, тайлга, тахилга үйлдэх нь эрт дээр үеэс уламжлалтай бөгөөд XIII зууны үед хэвээр хадгалагджээ. Тухайлбал: “Түүхэн тэмдэглэл”-д дурьдсанаар Эртний Хүннүчүүд “Тэргэл саран үзэгдэх үед дайнд мордох” (17.т.195.) цэргийн сүсэгтэй хэмээсэн байдгаас үзвэл тэр нь нилээд эртний уламжлалыг хадгалсан хэрэг гэлтэй;**
- **Энэ өдөр нь Монголчуудын алиев хэрэг явдлыг эхлэх, хөдөлмөр, аж ахуйн онцлоогийг илэрхийлсэн төдийгүй тухайн үедээ нийлэн нягтрахын бэлэгдэл байжээ. Нөгөөтэйгүүр тэр үеийн Монголчуудын ертөнцийг үзэх үзэл, цаг тооны цаглабарын хувьд чухал үүрэг гүйцэтгэж байсан ажээ.**
- **Мөн энэ өдөр Монголчуудын байгаль, эх дэлхийтэйгээ харьцах, улмаар түүнд шүтэн бишрэх, ахуй байдлын өвөрмөц тал, тэдний далдын алиев нэгэн ид шидэнд итгэх, ямарваа зүйлийг цаад эзэн биетэй гэж үзэж байсны улбаа мөн байж болох юм.**
- **Чингис хаан уг өдрийг эхэд эрхэмлэн алиев тахилга болоод бусад олон зүйлийг хийдэг байсан бололтой бөгөөд тэр нь эртний уламжлалыг хүндэтгэсэн хэрэг байв. Өөрөөр хэлбэл, Чингис хаан эл өдөр алиев нэгэн тахилга хийх болон бусад зүйлийн хэрэг явдал эрхлэхийг төрийн хэмжээнд болгосон байна.**

Ном зүй

- Лу "Алтан товч". УБ., 1990.
Владимирцов В.Я. Общественный строй Монголов. М., 1934.
Гаадамба Ш. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал. УБ., 1990.
Гонгор Д. Халх товчоон. Боть II, УБ., 1978.
Гүн Гомбожав. Чингис эзний алтан ургийн түүх гангын урсгал нэрт бичиг оршив. УБ., 1992.
Далай Ч. Их Монгол улс (1206-1260). УБ., 1994.
Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1988.
<<Монголын нууц товчоо>> (ред. Ц. Дамдинсүрэн) УБ., 1990.
<<Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан Олон улсын бага хурал>>. Боть 1, УБ., 1995.
Нацагдорж Ш. Чингис хааны цадиг. УБ., 1991.
Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988.
Сайшаал. Чингис хааны товчоон. Тэргүүн дэвтэр. Хөх хот, 1987.
Сайшаал. Чингис хааны товчоон. Дэд дэвтэр. Хөх хот, 1987.
Саган сэцэн. Эрдэний товч. (хэвлэлд бэлтгэсэн Ц. Насанбалжир), УБ., 1961.
Чингэл Г. Чингис хааны тухай товч тайлбар толь. УБ., 1992.
<<Монголын нууц товчоо>>. (Б. Сумьяабаатар-Үсгийн галиг.) УБ., 1990.
Хүй рүн. Чингис хааны гүн ухааны үзэл санааны судлал. Хөх хот, 1998.

Хураангуй

И.Саруул

Тус өгүүлэлд Монголын угсаатан судлалын шинжлэх ухаанд хэрэглэгдэж буй үндсэн онолыг нэгтгэсэн болно. Эдгээрийг цаашид боловсруулж, монгол угсаатны соёлын үзэл баримтлалд нийцүүлэх шаардлагатай.